

**ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (гарц буюу ажил, үйлчилгээ)	Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нэгжийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин Хэрэгжилт
1	2	3	4
2.1. Үндэсний статистикийн системийн хүрээнд албан ёсны статистикийн мэдээллийн чанар, бодит байдал, уялдаа холбоо, шуурхай, хүртээмжтэй байдлыг сайжруулах зохицуулалтын үр нөлөөтэй хөшүүргийг бий болгох зорилтын хүрээнд			
2.1.3.3. Статистикийн салбарын албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг явуулах, орчин үеийн шаардлагад нийцсэн зайны сургалтын орчныг бүрдүүлэх;	2.1.3.3.1. Төлөвлөгөөт болон цаг үеийн шаардлагаар Статистикийн тухай хууль, Хүн ам өрхийн мэдээллийн сан бусад хууль тогтоомж, нэмэлт тооллого судалгааны зайны сургалт зохион байгуулах 2.1.3.3.2. Статистикийн үйл ажиллагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллана.	Үндэсний статистикийн тогтолцоог сайжруулж, бэхжүүлэн, статистикийн мэдээллийн чанар сайжирч, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нэмэгдэнэ.	2.1.3.3.1. Сумдын Статистик хариуцсан ажилтнууд болон БЗД нарт ХААТС, жилийн эцсийн мал тооллогын цахим сургалтыг 2 удаа 114 хүнийг хамруулж зохион байгуулан, тооллого судалгааны арга аргачлал мэдээллийн санг сайжруулах чиглэл өгсөн. 2.1.3.3.2. Хэлтсийн шинэ албан хаагчдад болон 52 ААНБ-ын төлөөллийг хамруулан Статистикийн салбарын хууль эрх зүйн сургалтыг зохион байгуулж, хуулийг хэрэгжүүлж ажиллахад зөвлөмж өгч ажилласан.
2.1.3.4. Үндэсний статистикийн системийн байгууллага, нэгжийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, солилцох, тархаах ажлын уялдааг хангаж, арга зүйг	2.1.3.4.1. Статистикийн тухай хуулийн дагуу хийгдэж байгаа мэдээ тайлан, тооллого судалгааны ажилд явцын мониторинг хийж мэргэжлийн зөвлөгөө туслалцааг шуурхай өгч, мэдээллийн чанарын шаардлага хангуулж, ажиллах	Үндэсний статистикийн тогтолцоог сайжруулж, бэхжүүлэн, статистикийн мэдээллийн чанар сайжирч,	2.1.3.4.1. 10 жил тутам зохион байгуулагддаг ХАОСТ-ын хяналтыг тус хэлтэс, Аймгийн ХАОСТ-ын комисстой хамтран 7 чиглэлд хяналтын баг ажиллуулж, аймгийн бүх сумдыг хамрууллаа. 2020 онд Хагас жилийн мал тооллогын хяналт, ХААТС болон Статистик мэдээ, тайлангийн явцын хяналт, Жилийн эцсийн

<p>сайжруулах, боловсронгуй болгох.</p>		<p>бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нэмэгдэнэ.</p>	<p>мал, тэжээвэр амьтдын тооллогын хяналтын ажлаар нийт 15 суманд 2 удаа ажилласан байна. Ажиллах хугацаандаа сумдын удирдлагуудтай уулзаж тооллого, судалгааны зохион байгуулалтын талаар хэлэлцэж, сумдын Статистик хариуцсан ажилтнуудын статистик мэдээний маягтыг алдаагүй бүрэн бөглөсөн эсэх, шивэлтийг алдаагүй зөв шивэх талаар заавар, зөвлөмжийг дор бүр өгч ажилласан.</p>
<p>2.1.5. Мэдээлэл тархаалтын олон улсын стандартад нийцсэн тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>2.1.5.3.Нээлттэй мэдээллийн стандартын дагуу хэрэглэгчид статистикийн мэдээллийг хүртээмжтэй, шуурхай хүргэх боломжийг бүрдүүлж, нээлттэй мэдээллийн нэгдсэн систем байгуулж, хөгжүүлэх; 2.1.5.7.Хэвлэмэл бүтээгдэхүүний нэгдсэн загвар, стандартыг боловсруулж, мөрдөх; 2.1.5.9. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол давтамжтайгаар зохион байгуулах.</p>	<p>Хэрэглэгчдэд статистикийн мэдээллийг нээлттэй хэлбэрээр тогтсон хуваарийн дагуу тархааж хэвшсэн байна.</p>	<p>2.1.5.3. Статистик мэдээг нээлттэй нэг стандартын дагуу хүртээмжийг сайжруулж хүргэхийн тулд Статистик мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг сум багаар бэлтгэн ҮСХ-нд хүргүүлж ажилласан. Мөн хэлтсийн сайтын мэдээллийн сан болох динамик мэдээллийг 19 нэр төрлийн 170 үзүүлэлтээр баяжуулсан. 3 төрлийн 6 үзүүлэлт шинээр нэмсэн. 2.1.5.7. 2018 оны 12 сарын 7-нд батлагдсан Хэвлэмэл бүтээгдэхүүний нэгдсэн загвар, стандартын дагуу Хэлтсээс гарч байгаа бүх хэвлэмэл бүтээгдэхүүнд мөрдөж ажиллаж байна. 2.1.5.9. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хүссэн хэрэглэгч хэзээ ч өгөх боломжийг бүрдүүлэн, үр дүнг жил бүр тайлагнан ажиллаж байна.</p>
<p>2.1.7.Хэрэглэгчийн статистикийн боловсролыг дээшлүүлэх</p>	<p>2.1.7.19. Хэрэглэгчдэд ойлгомжтой, хялбар байдлаар статистикийн аргачлал, арга зүйг дүрст болон инфографик хэлбэрээр бэлтгэж, онлайн мэдээллийн хэрэгсэл цахим хуудас, нийгмийн сүлжээгээр олон нийтэд хүргэж хэвших</p>	<p>Статистикийн талаархи мэдлэг нэмэгдэж, статистикийн мэдээллийн хэрэглээ нэмэгдсэн байна.</p>	<p>2.1.7.19. Статистик мэдээллийг Хэрэглэгчдэд ойлгомжтой инфографик хэлбэрээр бэлтгэж, онлайнаар болон хэвлэмээр олон нийтэд түгээж заншсан. 2020 онд сэдэвчилсэн, баяр ёслолд зориулсан 18 инфографик хийж цахимаар олон нийтэд үйлчилсэн байна.Мөн Сар улирал, 7 хоног тутамд шинэчлэгддэг инфографикийг оруулбал нийт 72 инфографик хийсэн байна.</p>

	2.1.7.18.Мөрдөж байгаа салбарын статистикийн аргачлал, арга зүйг хэрэглэгчид ойлгомжтой дүрст болон инфографик хэлбэрээр бэлтгэж, онлайн мэдээллийн хэрэгсэл, хэлтсийн албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээгээр олон нийтэд хүргэж хэвших		2.1.7.18. Мөрдөж байгаа салбарын статистикийн аргачлал, арга зүйг хэрэглэгчид ойлгомжтой дараах байдлаар хүргэж ажилласан. Үүнд: ХАОСТ-ын тооллогын 2 төрлийн шторк, ААНБ Статистик мэдээг хэрхэн онлайнаар өгөх зааврын шторк, Нийт мэдээ, судалгааны аргачлалын 4 инфографик хийж мэдээлэгчдийг тэдэнд ойрхон нийгмийн сүлжээгээр хүргэлээ.
2.1.11.Орон нутгийн статистикийн байгууллагын ажлын ачааллыг оновчтой зохион байгуулах	2.1.11.2.Судалгааны мэргэшсэн судлаачдыг тогтвор, суурьшилтай ажиллуулж, үндэсний хэмжээний тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээлэл бүрдүүлэлтийн чанарыг хангаж ажиллах;	жилдээ	2.1.11.2.Судалгааны мэргэшсэн судлаачдыг тогтвор, суурьшилтай ажиллах зорилгоор тэднийг дэмжиж, сургалтанд тогтмол хамруулж түүвэр судалгааны анхдагч мэдээллийн чанарыг хангаж ажиллалаа. /Хэлтсийн 3 судлаач 2020 оны 8 сарын 10-12нд, 2020 оны 10 сард Хэнтий аймагт болсон судлаачдын сургалтанд тус тус хамруулсан/
2.4.Мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгын хүрээнд			
2.4.3.Хэрэглэгчид мэдээллийг онлайнаар авах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:	2.4.3.1.Статистикийн мэдээллийг хэрэглэгч онлайнаар хялбар авах шуурхай, нээлттэй системийг хөгжүүлэх; 2.4.3.2.Статистикийн мэдээллийг засаг, захиргааны нэгж, стандарт, ангиллын нарийвчилсан, дэлгэрэнгүй түвшинд авах боломжийг бүрдүүлэх.	Хэрэглэгч орон зай, цаг хугацаанаас үл хамааран статистикийн мэдээллийг онлайнаар шууд авдаг болно	2.4.3.1.Статистикийн мэдээллийг хэрэглэгч онлайнаар хялбар авах шуурхай, нээлттэй системийг дараах байдлаар бий болгож байна. -Статистик мэдээллийн нэгдсэн сан 1212.mn сайтаар дамжуулан бүх төрлийн Статистик мэдээг Англи, Монгол хэл дээр дэлхийн өнцөг булан бүрээс, 24 цагийн турш авах боломжийг бүрдүүлсэн. -Аймгийн хэмжээний шинэ Статистик мэдээллийг тогтмол Дундговь аймгийн Статистикийн хэлтэс нээлттэй пэйж хуудас, Хэлтсийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан түгээж байна. 2.4.3.2.Статистикийн мэдээллийг засаг, захиргааны нэгж, стандарт, ангиллын нарийвчилсан, дэлгэрэнгүй түвшинд авах боломжийг бүрдүүлэх зорилгоор боломжит 6

			төрлийн мэдээллийг аймаг, сум багийн түвшинд гарган Статистик мэдээллийн нэгдсэн сан болон хэлтсийн сайтад байршууллаа.
2.4.7. Статистикийн мэдээллийн нэгдсэн санд суурилсан нээлттэй мэдээллийн апплекэйшнийг ашиглах хүрээнд Статистик мэдээллийн нэгдсэн сангийн үзүүлэлтийг цахим үйлчилгээнд шилжүүлнэ.	2.4.7.3. www.1212.mn мэдээллийн нэгдсэн сан болон 1212.mn -ийг сурталчилах	Хэрэглэгч орон зай, цаг хугацаанаас үл хамааран статистикийн мэдээллийг онлайнаар шууд авдаг болно.	2.4.7.3. 2020 онд Статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайтыг дараах байдлаар сурталчиллаа. Аймгийн сарын танилцуулгын прэнсэнтэйшнтэй хамтатган 12 удаа, Хэлтсээс зохион байгуулсан хэрэглэгчдэд зориулсан 7 сургалтанд нийт 312 хүнд, хэлтсийн цахим хуудас болон хэлтсийн пэйж хуудсаар дамжуулан сурталчилав.

ТАЙЛАН ГАРГАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА

Т.БЯМБАСҮРЭН
Б.ЭНХТУЯА

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2021 оны 1 сарын 15